



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Сайхан сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: СЭА-2023/167/-НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.selenge@audit.gov.mn Сүхбаатар сум 2023 он</p>	<p>Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 70363040 Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 70363036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn Аудитыг гүйцэтгэсэн: Пийк-Ом Аудит ХХК Утас: 99052418 Цахим хаяг: cheegii9989@gmail.com</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Аудитын дүгнэлт
 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл
 3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
 - 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа
 - 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....
 - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....
 - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт
 - 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....
 4. Аудитын тайлан
 - 4.1 Ерөнхий зүйл
 - 4.2 Материаллаг байдал
 - 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....
 - 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
 - 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
 - 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал
5. Аудитын илрүүлэлт
 6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
БШУС	Боловсрол, шинжлэх ухааны сайд
БШУГ	Боловсрол, шинжлэх ухааны газар
ЗГ	Засгийн газар
БЕГ	Боловсролын ерөнхий газар
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ХНХС	Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
СӨБ	Сургуулийн өмнөх боловсрол
БШУЯ	Боловсрол, шинжлэх ухааны яам
БҮХТ	Боловсролын үнэлгээний хөгжлийн төв



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

СЭЛЭНГЭ АЙМГИЙН САЙХАН СУМЫН
1 ДҮГЭЭР ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
Т.УРАНЧИМЭГ ТАНАА

2023.02.25 № СЭА-2023/167-НА-СТА-ТШЗ.
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Сайхан сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сэлэнгэ аймгийн Сайхан сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Сэлэнгэ аймгийн Сайхан сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2022 оны үйл ажиллагаанд зарцуулахаар төлөвлөсөн санхүүжилтийг бүрэн төвлөрүүлж, төсвийн гүйцэтгэл 89.9 хувьтай тайлагнагдсан байна.

Цалин хөлс, нэмэгдэл урамшлын зардал 56,528.0 мянган төгрөг, НДШ 7,002.9 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 1,824.7 мянган төгрөг, нормативт зардал 1,062.8 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамжийн зардал 960.5 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардал 93.0 мянган төгрөг тус тус хэмнэснээс голлон шалтгаалж, нийт батлагдсан төсөв 67,471.9 мянган төгрөгөөр хэмнэгдсэн байна.

Аудитын гол асуудал

018020134

Сэлэнгэ аймгийн Сайхан сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2022 оны нийт төсвийн зарцуулалт, ажил гүйлгээний 62.9 хувийг цалин хөлс, нэмэгдэл урамшил, ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардал, 20.0 хувийг байр ашиглалттай холбоотой тогтмол зардал тус тус эзэлж байна.

Тус байгууллага нь Боловсролын Ерөнхий газрын 2022 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн А/343 дугаар тушаалаар сургалтын байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээний үр дүнгээр 1 дүгээр түвшинд үнэлэгдэж урамшуулалд 14,457.7 мянган төгрөгийн санхүүжилт авч зарцуулсан байна.

Бусад асуудлын хэсэг

Санхүүгийн тайланд танилцуулж, тодруулснаас бусад аудиторын шийдлээр онцлох асуудал байхгүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж, толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/ төгрөгөөр /

Данс	Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
I	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	22,449,769.3	95,598,142.4
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ		64,151,425.6
312	Банкинд байгаа бэлэн мөнгө		64,151,425.6
3121	Төгрөг		64,151,425.6
31211	Төрийн сангийн харилцах		64,151,425.6
33	АВЛАГА	175,142.8	1,913,150.3
331	Ажиллагчидтай холбогдсон авлага	175,142.8	1,913,150.3
35	БАРАА МАТЕРИАЛ	22,274,626.5	29,533,566.5
354	Хангамжийн материал	22,274,626.5	29,533,566.5
3541	Бичиг хэргийн материал	9,900.0	267,500.0
3542	Аж ахуйн материал	6,285,405.0	6,308,845.0
3546	Хүнсний материал	455,800.0	
3547	Бусад хангамжийн материал	15,523,521.5	22,957,221.5
II	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	453,077,898.2	422,591,912.8
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	453,077,898.2	422,591,912.8
392	Биет хөрөнгө	439,093,498.3	408,920,012.9
39201	Барилга, байгууламж, орон сууц	448,873,292.0	448,873,292.0
39202	Хуримтлагдсан элэгдэл	- 49,870,846.9	- 70,111,356.8
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	36,349,534.0	41,749,434.0
39206	Хуримтлагдсан элэгдэл	- 13,482,544.3	- 23,912,310.7
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	21,643,630.0	21,643,630.0
39208	Хуримтлагдсан элэгдэл	- 5,701,335.5	- 10,272,330.7
39214	Бусад үндсэн хөрөнгө	3,267,935.0	3,267,935.0
39215	Хуримтлагдсан элэгдэл	- 2,248,626.0	- 2,580,739.9
39217	Ном	262,460.0	262,460.0
393	Биет бус хөрөнгө	13,984,400.0	13,671,899.9
39301	Програм хангамж	1,625,000.0	1,625,000.0
39302	Хуримтлагдсан элэгдэл	- 1,000,000.0	- 1,312,500.1
39303	Бусад биет бус хөрөнгө	13,359,400.0	13,359,400.0
III	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	475,527,667.5	518,190,055.2
IV	НИЙТ ӨР ТӨЛБӨР	19,357,729.8	225,000.0
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	19,357,729.8	225,000.0
413	Өглөг	19,357,729.8	225,000.0
4132	Бараа үйлчилгээний зардлын өглөг	19,357,729.8	
4136	Бусад өглөг		225,000.0
41361	Байгууллагад төлөх өглөг		225,000.0
V	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	456,169,937.7	517,965,055.2
51	Засгийн газрын хувь оролцоо	456,169,937.7	517,965,055.2
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	229,741,717.0	229,741,717.0
51101	Өмч: - төрийн	229,741,717.0	229,741,717.0
512	Хуримтлагдсан үр дүн	- 71,035,937.0	- 9,240,819.5
5121	Өмнөх үеийн үр дүн	- 71,035,937.0	- 546,388,461.7
5122	Тайлант үеийн үр дүн		537,147,642.2
513	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	297,464,157.7	297,464,157.7
VI	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	475,527,667.5	518,190,055.2

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/ төгрөгөөр /

Данс	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	453,184,536.0	1,143,158,520.7
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	10,908,336.0	479,207,524.7
120	Нийтлэг татварын бус орлого	10,908,336.0	479,207,524.7
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	5,610,790.0	35,000.0
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		35,000.0
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	5,610,790.0	
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө		456,677,898.2
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	5,297,546.0	22,494,626.5
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	442,276,200.0	663,950,996.0
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	382,913,400.0	522,477,400.0
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		522,477,400.0
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	382,913,400.0	
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	276,000.0	
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	276,000.0	
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	59,086,800.0	141,473,596.0
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	59,086,800.0	141,473,596.0
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	464,435,316.0	606,010,878.5
21	УРСГАЛ ЗАРДАЛ	464,435,316.0	606,010,878.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	436,237,375.0	591,553,178.5
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	281,740,732.2	333,822,769.5
210101	Үндсэн цалин	202,166,337.2	237,564,063.8
210102	Нэмэгдэл	58,747,016.0	70,470,495.0
210104	Урамшуулал	20,827,379.0	8,662,834.0
210105	Гэрээт ажлын хөлс		17,125,376.7
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	36,804,624.0	42,025,826.4
210201	Тэтгэврийн даатгал	25,787,462.4	28,767,789.4
210202	Тэтгэмжийн даатгал	2,792,400.2	2,656,741.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,350,812.6	3,320,927.0
210204	Ажилгүйдлийн даатгал	529,359.2	655,189.0
210205	Эрүүл мэндийн даатгал	5,344,589.6	6,625,180.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	57,532,340.8	100,884,607.1
210301	Гэрэл, цахилгаан	4,013,051.0	6,117,436.0
210302	Түлш, халаалт	48,973,044.8	87,331,705.1
210303	Цэвэр, бохир ус	4,546,245.0	7,435,466.0
2104	Хангамж, бараа материалын зардал	3,716,984.0	
210401	Бичиг хэрэг	326,100.0	
210402	Тээвэр, шатахуун	12,000.0	
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	896,400.0	
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	950,400.0	
210408	Бараа материал акталсны зардал	1,532,084.0	
2105	Нормативт зардал	20,936,650.0	62,703,200.0
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	106,700.0	
210502	Хоол, хүнс	20,389,850.0	62,703,200.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	440,100.0	
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,362,100.0	1,496,030.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	25,000.0	
210604	Урсгал засвар	1,337,100.0	1,496,030.0
2107	Томилолт, зочны зардал	140,000.0	
210702	Дотоод албан томилолт	140,000.0	

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,291,000.0	445,500.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	643,000.0	
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	648,000.0	
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ		445,500.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	32,712,944.0	50,175,245.4
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		11,053,760.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,922,810.0	3,235,600.0
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	29,790,134.0	35,885,885.4
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	28,197,941.0	14,457,700.0
2132	Бусад урсгал шилжүүлэг		14,457,700.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		14,457,700.0
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	28,197,941.0	
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	28,197,941.0	
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	- 11,250,780.0	537,147,642.2
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	979,046.0	
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	979,046.0	
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	- 979,046.0	
V	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	- 12,229,826.0	537,147,642.2

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/ төгрөгөөр /

Данс	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	442,276,200.0	663,985,996.0
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО		35,000.0
120	Нийтлэг татварын бус орлого		35,000.0
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого		35,000.0
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		35,000.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	442,276,200.0	663,950,996.0
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	382,913,400.0	522,477,400.0
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		522,477,400.0
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	382,913,400.0	
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	276,000.0	
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	276,000.0	
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	59,086,800.0	141,473,596.0
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	59,086,800.0	141,473,596.0
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	435,401,200.0	598,034,670.3
21	УРСГАЛ ЗАРДАЛ	435,401,200.0	598,034,670.3
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	407,203,259.0	583,576,970.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	281,915,875.0	334,957,956.4
210101	Үндсэн цалин	199,271,086.0	237,608,920.4
210102	Нэмэгдэл	61,845,949.0	71,299,309.0
210104	Урамшуулал	20,798,840.0	8,662,834.0
210105	Гэрээт ажлын хөлс		17,386,893.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	36,804,624.0	42,628,647.0
210201	Тэтгэврийн даатгал	25,787,462.4	29,211,608.9
210202	Тэтгэмжийн даатгал	2,792,400.2	2,988,077.4
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,350,812.6	3,044,344.1
210204	Ажилгүйдлийн даатгал	529,359.2	659,409.7
210205	Эрүүл мэндийн даатгал	5,344,589.6	6,725,206.9

2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	58,563,900.0	120,242,337.0
210301	Гэрэл, цажилгаан	4,013,051.0	6,117,436.0
210302	Түлш, халаалт	50,004,604.0	106,689,435.0
210303	Цэвэр, бохир ус	4,546,245.0	7,435,466.0
2104	Хангамж, бараа материалын зардал	2,415,300.0	
210401	Бичиг хэрэг	239,000.0	
210402	Тээвэр, шатахуун	12,000.0	
210404	Ном, хэвлэл	60,000.0	
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	896,400.0	
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,207,900.0	
2105	Нормативт зардал	22,053,150.0	62,247,400.0
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	106,700.0	
210502	Хоол, хүнс	20,823,150.0	62,247,400.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,123,300.0	
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,362,100.0	1,496,030.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	25,000.0	
210604	Урсгал засвар	1,337,100.0	1,496,030.0
2107	Томилолт, зочны зардал	140,000.0	
210702	Дотоод албан томилолт	140,000.0	
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,291,000.0	445,500.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	643,000.0	
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	648,000.0	
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ		445,500.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,657,310.0	21,559,100.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		17,329,100.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага жийх	2,657,310.0	4,230,000.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	28,197,941.0	14,457,700.0
2132	Бусад урсгал шилжүүлэг		14,457,700.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		14,457,700.0
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	28,197,941.0	
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	28,197,941.0	
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	6,875,000.0	65,951,325.6
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
IV	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)		
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	6,875,000.0	1,799,900.0
22	Биет ба биет бус хөрөнгө худалдан авах	6,875,000.0	1,799,900.0
	Дотоод эхүүсвэрээр	6,875,000.0	1,799,900.0
223001	Бусад хөрөнгө	6,875,000.0	1,799,900.0
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	- 6,875,000.0	- 1,799,900.0
VII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)		64,151,425.6
31	Мөнгө, түүнтэй адилгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		64,151,425.6

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Д/Д	Үзүүлэлт	Засгийн газрын сан	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	ЗГ-н хувь оролцооны дүн
1	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл				
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл				
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				
10	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	229,741,717.0	297,464,157.7	- 71,035,937.0	456,169,937.7
11	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			- 475,352,524.7	- 475,352,524.7
12	Дахин илэрхийлсэн үлдэгдэл				
13	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				
16	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				
17	Тайлант үеийн үр дүн			537,147,642.2	537,147,642.2
19	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	229,741,717.0	297,464,157.7	- 9,240,819.5	517,965,055.2

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

Д/Д	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү дүн	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	667,306,500.0	599,834,570.3	67,471,929.7	89.9
21	УРСГАЛ ЗАРДАЛ	667,306,500.0	599,834,570.3	67,471,929.7	89.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	652,848,800.0	585,376,870.3	67,471,929.7	89.7
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	391,486,000.0	334,957,956.4	56,528,043.6	85.6
210101	Үндсэн цалин	300,775,800.0	237,608,920.4	63,166,879.6	79.0
210102	Нэмэгдэл	62,635,700.0	71,299,309.0	- 8,663,609.0	113.8
210104	Урамшуулал	9,497,300.0	8,662,834.0	834,466.0	91.2
210105	Гэрээт ажлын хөлс	18,577,200.0	17,386,893.0	1,190,307.0	93.6
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	49,631,500.0	42,628,647.0	7,002,853.0	85.9
210201	Тэтгэрийн даатгал	33,748,800.0	29,211,608.9	4,537,191.1	86.6
210202	Тэтгэмжийн даатгал	4,023,300.0	2,988,077.4	1,035,222.6	74.3
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,162,500.0	3,044,344.1	118,155.9	96.3
210204	Ажилгүйдлийн даатгал	790,600.0	659,409.7	131,190.3	83.4
210205	Эрүүл мэндийн даатгал	7,906,300.0	6,725,206.9	1,181,093.1	85.1
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	122,067,000.0	120,242,337.0	1,824,663.1	98.5
210301	Гэрэл, цахилгаан	8,526,800.0	6,117,436.0	2,409,364.0	71.7
210302	Түлш, халаалт	104,955,000.0	106,689,435.0	- 1,734,435.0	101.7
210303	Цэвэр, бохир ус	8,585,200.0	7,435,466.0	1,149,734.0	86.6
2105	Нормативт зардал	63,310,200.0	62,247,400.0	1,062,800.0	98.3
210502	Хоол, хүнс	63,310,200.0	62,247,400.0	1,062,800.0	98.3
2106	Эд хопшил, урсгал засварын зардал	1,496,100.0	1,496,030.0	70.0	100.0
210604	Урсгал засвар	1,496,100.0	1,496,030.0	70.0	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,406,000.0	445,500.0	960,500.0	31.7
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,406,000.0	445,500.0	960,500.0	31.7
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	23,452,000.0	23,359,000.0	93,000.0	99.6
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	19,222,000.0	19,129,000.0	93,000.0	99.5
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,230,000.0	4,230,000.0		100.0

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	14,457,700.0	14,457,700.0		100.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	14,457,700.0	14,457,700.0		100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	14,457,700.0	14,457,700.0		100.0
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХҮҮСВЭР	663,985,996.0	663,985,996.0		100.0
131	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	522,477,400.0	522,477,400.0		100.0
131001	Улсын төсвөөс санхүүжих	522,477,400.0	522,477,400.0		100.0
132	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	141,473,596.0	141,473,596.0		100.0
132001	Орон нутгийн төсвөөс	141,473,596.0	141,473,596.0		100.0
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	35,000.0	35,000.0		100.0
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	35,000.0	35,000.0		100.0
31	Мөнгө, түүнтэй адилгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		64,151,425.6	-64,151,425.6	
2	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.0	1.0		
5	АЖИЛЛАГСАДЫН ТОО	25.0	25.0		
24	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	25.0	25.0		

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1. Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сэлэнгэ аймгийн Сайхан сумын 1 дүгээр цэцэрлэгийн “Бага насны хүүхдийн хөгжлийг хангахад хамтран ажиллаж суралцах, ажиллах орчин нөхцөлийг бүрдүүлэх” гэсэн эрхэм зорилгын хүрээнд үйл ажиллагаагаа явуулсан байна.

Үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Цэцэрлэгийн хамран сургах тойргийн сургуулийн өмнөх насны хүүхдийг цэцэрлэгт хамруулах, 5 настай хүүхдийг сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд хамруулан сургуульд суралцах бэлтгэлийг хангах.
- Хичээл сургалтын үйл ажиллагааг хүүхдийн сонирхол, хэрэгцээнд нийцүүлэн зохион байгуулах, арга зүйг сайжруулах.
- Хүүхдүүд цэцэрлэгтээ айдасгүй, амар тайван суралцах, эрүүл, аюулгүй, тэгш хүртээмжтэй орчинд суралцах, хөгжих боломжоор хангах
- Бага насны хүүхэд болон багш, ажилчдын эрүүл мэнд, хөдөлгөөнийг дэмжсэн үйл ажиллагааг чанартай зохион байгуулах
- Багшийн ажлын гүйцэтгэлд суурилан тасралтгүй хөгжих олон хэлбэрт сургалт, үйл ажиллагааг зохион байгуулах, мэргэжлийн зэрэгтэй багшийн манлайлал, үүрэг оролцоог нэмэгдүүлэх
- Багш ажилтан бүр ёс зүйн хэм хэмжээ, шаардлагыг мөрдөж, төсвийг төлөвлөх, үр ашигтай зарцуулахад оролцох
- Хүүхдийн хөгжил, хүүхэд хамгааллын ажилд эцэг эх, асран хамгаалагч нарын оролцоог нэмэгдүүлэх

3.2. Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2022 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилтийг баталсан,
- Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдсөн байна.
- Төрийн хэмнэлтийн тухай тухай хууль хэрэгжиж эхэлсэн,
- Төрийн албаны тухай хуульд 2022 оны 04 дүгээр сарын 22, 07 дугаар сарын 05, 11 дугаар сарын 11-нд нэмэлт өөрчлөлт орсон.
- Боловсролын тухай хуульд 2022 онд 3 удаа нэмэлт өөрчлөлт орсон,
- ЗГ-ын 2022 оны 91 дүгээр тогтоолоор батлагдсан “Хувьсах зардлын дундаж норматив, аргачлал батлах тухай” журам хэрэгжиж эхэлсэн,
- ЗГ-ын 2019 оны 472 дугаар тогтоолын 5, 6 дугаар хавсралтаар батлагдсан “Шинжлэх ухааны байгууллага, сургуулийн өмнөх болон бага, дунд боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллагын төрийн үйлчилгээний албан тушаалын цалингийн сүлжээ батлах тухай” тогтоолд 2022 оны 107 дугаар тогтоолоор батлагдсан “Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг тогтоох тухай” тогтоол, 2022 оны 192 дугаар тогтоолоор нэмэлт өөрчлөлт оруулсан,
- ЗГ-ын 2019 оны 5 дугаар тогтоолын гуравдугаар хавсралтаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын багш, туслах багш, албан хаагчид олгох улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгох” тогтоолд 2022 оны 252 дугаар тогтоолоор нэмэлт өөрчлөлт оруулсан,
- БШУС-ын 2022 оны А/170 дугаар тушаалаар батлагдсан “Хичээл, сургалтын үйл ажиллагааны зардлыг төлөвлөх, хуваарилах заавар”-ыг хэрэгжүүлж эхэлсэн,
- БШУС-ын 2022 оны А/465 дугаар тушаалаар батлагдсан “Ерөнхий боловсролын сургуульд, кабинет, лаборатори, цахим сургалтын танхим байгуулах, ашиглах нийтлэг журам”-ыг шинэчлэн баталсан,
- ХНХС-ын 2021 оны А/192 дугаар тушаалаар батлагдсан “Дундаж цалин хөлс тодорхойлох журам” хэрэгжиж эхэлсэн.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналт, үйл ажиллагааны зохион байгуулалтын хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзлээ.

Тайлант онд дээд шатны төсвийн захирагч болох БШУЯ-ны зүгээс дотоод аудит, хяналт, шалгалт хийгдээгүй бөгөөд дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3. Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сайхан сумын 1 дүгээр цэцэрлэг нь 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

Тус байгууллага нь өмнөх жилүүдэд тусгай зориулалтын шилжүүлгээр санхүүждэг байсан учир Сэлэнгэ аймгийн ЗД-ын 2020 оны 7 дугаар сарын 16-ны өдрийн А/202 дугаар захирамжаар баталсан “Сэлэнгэ аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн багцад хамаарах төсөвт байгууллагуудад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг мөрдөж ирсэн байна.

Бүртгэлийн үйл ажиллагаанд мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн хэдий ч боловсролын байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирохгүй байна.

3.4. Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Сайхан сумын 1 дүгээр цэцэрлэг нь 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оныхоос 42,662.4 мянган төгрөгөөр буюу 9.0 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	64,151.4	64,151.4
Авлага	175.1	1,913.1	1,738.0
Бараа материал	22,274.6	29,533.6	7,259.0
Үндсэн хөрөнгө	453,077.9	422,591.9	(30,486.0)
Нийт хөрөнгө	475,527.6	518,190.0	42,662.4
Өр төлбөр	19,357.7	225.0	(19,132.7)

Засгийн газрын хувь оролцоо/Эздийн өмч/	456,169.9	517,965.0	61,795.1
Өр төлбөр ба цэвэр эздийн өмч	475,527.6	518,190.0	42,662.4

Тайлант жилийн үйл ажиллагааны зардлын хэмнэлт 64,151.4 мянган төгрөгийг Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралт “Хувьсах зардлын дундаж нормативаар төсөв хуваарилах, санхүүжүүлэх аргачлал”-ын 8.7-д “Боловсролын сургалтын байгууллагын жилийн эцсийн дансны үлдэгдлийг дараагийн төсвийн жилд шилжүүлнэ.” гэж заасны дагуу төрийн сангийн харилцах дансанд үлдэгдлээр тайлагнагдсан байна.

Авлага 1,913.1 мянган төгрөг болж 1,738.0 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд нягтлан бодогчийн тооцооллын алдаанаас шалтгаалан ХХОАТ-ын 545.8 мянган төгрөгийн, цалингийн 295.4 мянган төгрөг, НДШ-ийн 896.8 мянган төгрөгийн авлага шинээр нэмж үүссэнээс шалтгаалсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 29,533.5 мянган төгрөг болж 7,259.0 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 78,343.1 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, БШУГ-аас 220.0 мянган төгрөгийн сурах бичиг үнэ төлбөргүй орлогоор бүртгэж авсан болон үйл ажиллагаанд 71,304.1 мянган төгрөгийн хөрөнгийг зарцуулснаас шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл /анхны өртгөөр/ 530,781.2 мянган төгрөг болж 5,399.9 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 1,799.9 мянган төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авч, БШУГ-аас 3,600.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж үнэ төлбөргүй хүлээн авснаас шалтгаалсан байна.

Он дамжсан халаалтын өрийг тайлант онд бүрэн барагдуулсан боловч бараа үйлчилгээний бусад зардлын 225.0 мянган төгрөгийн өр төлбөр шинээр үүсгэсэн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 517,965.0 мянган төгрөг болж 61,795.1 мянган төгрөгөөр өссөн нь өмнөх үеийн болон тайлант үеийн үр дүнгээс шалтгаалсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 685,144.7 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 101,172.9 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 786,317.6 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас тоног төхөөрөмж, тавилга хэрэгсэл худалдан авах, нэг удаагийн буцалтгүй тэтгэмжийн зардал, төрийн үйлчилгээний алба хаагчдын цалинг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр тооцон 204,051.7 мянган төгрөгийг улсын төсвийн санхүүжилтээс хасаж 481,093.0 мянган төгрөгөөр,

төрийн үйлчилгээний алба хаагчдын цалинг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр тооцон 47,494.2 төгрөгөөр нэмэгдүүлж орон нутгийн төсвийг 148,667.1 мянган төгрөгөөр, нийт төсвийг 629,760.1 мянган төгрөгөөр баталсан байна.

2022 оны 09 дүгээр сард орон нутгийн төсвөөс төрийн үйлчилгээний ажилчдын цалин улсын төсвөөс санхүүжигдэхээр болж 3,873.0 мянган төгрөг хасагдсан, 2022 оны 12 дугаар сард хийсэн төсвийн зохицуулалтаар байгууллагын үйл ажиллагааг хэвийн явуулахад шаардагдах бараа үйлчилгээний бусад зардал, төрийн үйлчилгээний алба хаагчдын цалин, НДШ-ийн зардал, гүйцэтгэлийн үнэлгээний урамшуулал 41,384.4 мянган төгрөг, төсөвт байгууллагын өөрийн орлого 35.0 мянган төгрөг зэрэг нийт 667,306.5 мянган төгрөгийн эх үүсвэрийг баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 9 арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс 522,477.4 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 144,794.1 мянган төгрөг, төсөвт байгууллагын өөрийн орлого 35.0 мянган төгрөг зэрэг нийт 667,306.5 мянган төгрөгийн эх үүсвэрийг урсгал үйл ажиллагаанд захиран зарцуулахаар төлөвлөсөн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 599,834.6 мянган төгрөг буюу 89.9 хувьтай байгаа нь цалингийн зардлаас 56,528.0 мянган төгрөг, НДШ-ийн зардал 7,002.9 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 1,824.7 мянган төгрөг, хоолны зардал 1,062.8 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардал 960.5 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардал 93.0 мянган төгрөгөөр хэмнэгдсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

Хөтөлбөр	Д/д	Арга хэмжээ	/мянган төгрөгөөр/			
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
71801-Сургуулийн өмнөх боловсрол	1	Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	123,563.1	121,738.4	1,824.7	98.5
	2	Нийтлэг үйлчилгээ	21,231.0	19,735.2	1,495.8	92.9
	3	81605-Эрүүл мэндийг дэмжих	1,900.0	1,810.0	90.0	95.3
	4	81807-Цэцэрлэгийн хүүхдийн хоол	63,310.2	62,247.4	1,062.8	98.3
	5	81816-Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	1,566.1	1,566.1	0.0	100.0
	6	81823-Боловсролын байгууллагын багш ажилчдын мэргэжил дээшлүүлэх	1,900.0	1,900.0	0.0	100.0
	7	81834-Боловсролын стандарт сургалтын төлөвлөгөө сургалтыг хэрэгжүүлэх	385,574.9	324,574.6	61,000.3	84.2
	8	81835-Сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах	68,226.2	66,227.9	1,998.3	97.1

	9	81844-Гүнзгийрүүлсэн болон сургалтын орчинг сайжруулах	35.0	35.0	0.0	100.0
Дүн			667,306.5	599,834.6	67,471.9	89.9

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд тус сургууль нь нэмэлт санхүүжилтийн дансыг ашиглаагүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сайхан сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн хууль тогтоомжийн хэрэгжилтийг ханган ажиллах, батлагдсан төсвийн хүрээнд зардал гаргахтай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний дагуу “Пийк Ом Аудит” ХХК-ийн аудитор Б.Наранчимэг гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Сайхан сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Пийк Ом Аудит ХХК-д 2023 оны 01 дүгээр сарын 23-ний өдрийн 01 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн шатны материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 464,435.3 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 4,644.3 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Боловсролын ерөнхий газраас нийт боловсролын байгууллагуудад 2022 оны 04, 09 дүгээр саруудад төрийн хэмнэлтийн тухай хууль болон ЗГ-ын 2022 оны 203 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах, төсвийн хэмнэлтийн горимоор ажиллах, орон тоог хязгаарлах, төрийн үйл ажиллагааг цахимжуулах, бараа үйлчилгээний зардлыг бууруулах, зөвлөмжийг хүргүүлсэн байна.

Сайхан сумын 1 дүгээр цэцэрлэг нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийг дараах байдлаар хэрэгжүүлжээ. Үүнд:

- Боловсролын салбарын үр дүнд суурилсан санхүүжилтийг нэвтрүүлж батлагдсан орон тоогоор бус гүйцэтгэлээр санхүүжүүлсэнтэй холбоотойгоор цалин, ажил олгогчоос төлөх НДШ, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, хоолны зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардал, бараа үйлчилгээний бусад зардлаас нийт 67,471.9 мянган төгрөгийн хэмнэлтийг бий болгожээ.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд боловсролын байгууллагын мэдээлбэл зохих 20 төрлийн 170 мэдээллээс 9 мэдээллийг хугацаа хоцроож мэдээллийн хэрэгжилт 94.7 хувьтай байна.

Үүнд:

- Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт – 2 удаа
- Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт – 1 удаа
- Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө -2 удаа
- Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл, концессын зүйлийн жагсаалт, гүйцэтгэл – 2 удаа

- Бонд зээл, өрийн бичиг баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр -2 удаа

Шийдвэрлэсэн нь: Өмнөх аудитаар шилэн дансны цахим хуудаст мэдээлбэл зохих мэдээллийг хугацаанд нь мэдээлж байх гэх чиглэлээр өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэлгүйгээр тайлант онд давтан гаргасан тул МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1 дэх “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана.”, 4.2.1.10: “Аудитаар илэрсэн алдаа, зөрчил түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол” гэсэн заалтын дагуу албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

“Пийк Ом Аудит” ХХК-ийн 2022 оны 11 дүгээр 02-ны 200 дугаар албан бичгээр “Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай” захидлыг хүргүүлсэн бөгөөд тус байгууллагын 2022 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланд хийсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар нягтлан бодогчийн тооцооллын алдаанаас шалтгаалан 175.1 мянган төгрөгийн ХХОАТ-ын өр төлбөр үүсгэсэн зөрчлийг арилгах албан шаардлагыг хэрэгжүүлэлгүйгээр тайлант онд давтан гаргасан бөгөөд шилэн дансны мэдээллийг цахим системд тухай бүр мэдээлээгүй зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	2	88,342.7	1	88,342.7	50
Албан шаардлага	1	175,1			
Нийт дүн	3	88,517.8	1	88,342.7	33.3

Өмнөх аудитаар өр төлбөр, авлага үүсгэхгүй ажиллах албан шаардлагыг хэрэгжүүлэлгүйгээр тайлант онд зөрчлийг давтан гаргасан тул Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 дэх “Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй нь... аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын

шийтгэл ногдуулах үндэслэл болно” гэсэн заалтыг үндэслэн нягтлан бодогч Э.Батзаяад **сахилгын шийтгэл ногдуулах** албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараах асуудлууд нь тухайн төсвийн захирагчийн бус дээд шатны төсвийн захирагчийн шийдвэрээр хэрэгжсэн учир Сайхан сумын 1 дүгээр цэцэрлэгийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар зөрчлөөр тооцоолгүйгээр дээд шатны төсвийн захирагчийн санхүүгийн тайланд хийх аудитын анхааралд хандуулж байна. Үүнд:

1. Дээд шатны төсөв захирагчаас төсвийг зардлын эдийн засгийн ангиллаар нь бус “бараа үйлчилгээний бусад зардал” гэсэн ангиллаар бөөнд нь тусган, төлөвлөж, баталж байгаа нь төсвийг зардлын бүлэг, зүйлээр төлөвлөж, зарцуулах, зарцуулалтад хяналт тавих зарчмыг алдагдуулж байна. Иймд төсвийг бодит гүйцэтгэлтэй нь уялдуулан зардлын бүлэг, зүйл бүрээр төлөвлөж, зарцуулан гүйцэтгэж байх шаардлагатай байна.
2. Сангийн яамны 2022 оны 02 дугаар сарын 28-ны “*Чиглэл хүргүүлэх тухай*” албан бичгээр байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансыг хааж нэмэлт санхүүжилттэй холбоотой гүйлгээг урсгал дансаар дамжуулан “*Нэмэлт – Дээд шатны төсвөөс хуваарилсан*” гэсэн зориулалтаар, төсөвт байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлого /120010/ ангиллаар гүйцэтгэхээр чиглэл хүргүүлсэн байна. Нэмэлтээр хуваарилах төсвийн эх үүсвэрийг төсвийн санхүүжилтийн эх үүсвэр болгон төлөвлөж байгаагаас гүйцэтгэлээр уг санхүүжилт хуваарилагдаагүй тохиолдолд төсвийн санхүүжилтийн төлөвлөгөө тасарснаар тайлагнагдах эрсдэлийг үүсгэж байна. Иймд дээд шатны төсвөөс хуваарилах нэмэлт төсвийг төсвийн санхүүжилт хэлбэрээр урьдчилан төлөвлөж, батлалгүйгээр санхүүжилт ирсэн тухай бүр тухайн санхүүжилтийн дүнгээр зарцуулах эрх тавих нь зүйтэй юм.
3. Тус цэцэрлэгийн нягтлан бодогч Э.Батзаяа, нярав О.Ганчимэг нарын ажлыг улирал бүр дүгнэж, ажлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг тухай бүр үндсэн цалингийн 30.0-45.0 хувиар тооцож олгосон боловч Боловсролын Ерөнхий газрын даргын 2022 оны 1/643 дугаар тушаалаар салбарын санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг “**Зөрчилгүй**” дүгнүүлсэн гэх үндэслэлээр 1,388.6 мянган төгрөгийн урамшууллыг давхардуулан олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “*Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах*”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх “*Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно*”, 15.1.3: “*Хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох*” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.
Цаашид улирлын ажлын мөнгөн урамшуулалтай давхардуулан, хууль, эрх зүйн үндэслэлд нийцээгүй урамшуулал олгохгүй байх нь зүйтэй.
4. Тус байгууллага нь өмнөх жилүүдэд тусгай зориулалтын шилжүүлгээр санхүүждэг байсан учир Сэлэнгэ аймгийн ЗД-ын 2020 оны 7 дугаар сарын 16-ний өдрийн А/202 дугаар захирамжаар баталсан “*Сэлэнгэ аймгийн төсвийн*

ерөнхийлөн захирагчийн багцад хамаарах төсөвт байгууллагуудад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг"-ийг мөрдөж ирсэн байна.

Бүртгэлийн үйл ажиллагаанд мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн хэдий ч боловсролын байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирохгүй учир боловсруулсан салбарын төсвийн ерөнхийлөн захирагчийн НБББББ-ыг мөрдөх нь зүйтэй юм.

АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар алдаа илрээгүй болно.

Аудитаар нийт **6,449.6** мянган төгрөгийн зөрчил¹ илрүүлснээс 1,963.0 мянган төгрөгийн албан шаардлага, 4,486.6 мянган төгрөгийн алдаа зөрчилд зөвлөмж өглөө.

5.1 Албан шаардлага

1. 2022 оны жилийн эцсийн эд хөрөнгийн тооллого хийхдээ бичиг хэргийн материалыг тоолоогүй, бусад хангамжийн материалын тооллогын дүнг нэгтгэн дүгнээгүй байгаа зэрэг нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйл 12.2 дахь “Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ” 12.2.1-д “жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө, 20 дугаар зүйлийн 20.2.6. дахь “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, ...” гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Хөрөнгийн тооллогыг хууль тогтоомжийн дагуу үнэн зөв хийж гүйцэтгэж байх албан шаардлага хүргүүлэх.

2. Төсвийг зохистой удирдаагүй, төлбөр тооцоог урьдчилан хянаагүйн улмаас ХХОАТ-ын 545.8 мянган төгрөгийн, цалингийн 295.4 мянган төгрөгийн, НДШ-ийн 896,8 мянган төгрөгийн зэрэг нийт 1,738.0 мянган төгрөгийн авлага, байгууллагад төлөх 225.0 мянган төгрөгийн өр төлбөр шинээр үүсгэсэн байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийг зохистой удирдаж, төлбөр тооцоог урьдчилан хянасны үндсэн дээр өр төлбөр, авлага үүсгэхгүй ажиллах албан шаардлага хүргүүлэх

5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

1. Цалин хөлстэй холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт: Тайлант оны төсөвт тусгаагүй байхад багш, ажилтнуудад 4,486.6 мянган төгрөгийн илүү цагийн хөлсийг багш, ажилтнуудын 3 сарын дундаж цалингаас тооцож олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.5 дахь “төсвийн жилийн дундуур орлого бууруулах, зарлага нэмэгдүүлэх үр дагавартай бодлогын аливаа шийдвэр гаргасан бол түүнийг дараагийн төсвийн жилээс хэрэгжүүлдэг байх” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хууль тогтоомжийн хэрэгжилтийг ханган ажиллах, батлагдсан төсвийн хүрээнд зардал гаргах

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Дүн												

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Авлага, өр төлбөр үүсгэсэн	1	1,963.0			1	1,963.0						
2.Жилийн эцсийн эд хөрөнгийн тооллого бүрэн хийгээгүй	1				1							
Төсөвт тусгагдаагүй зардал гаргасан	1	4,486.6					1	4,486.6				
Сахилгын шийтгэл ногдуулах	1											
Дүн	4	6,449.6			2	1,963.0	1	4,486.6	1			

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Хугацаа хоцроосон	9				9			
Дүн	9				9			
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн	9				9			

**АЛЕАН ШААРДЛАГА, ТӨЛБӨРИЙН АКТЫН БҮРТГЭЛ,
ХЯНАЛТЫН ХУУДАС**

А. Албан шаардлага, төлбөрийн актын төсөл бэлтгэж, баталгаажуулах үеийн бүртгэл, хяналт

1. Ерөнхий мэдээлэл

1.1 Аудитын нэр	Сайхан сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийх аудит	1.2 Аудитын код	СЭА-2023/167-НА-СТА-ТШЗ
-----------------	---	-----------------	-------------------------

1.3 Аудит хийсэн үндэслэл	Төрийн аудитын тухай хуулийн 6.3.1, 8.1, Төсвийн тухай хуулийн 8.9.1	1.4 Аудитын төрөл	Санхүүгийн тайлангийн аудит
---------------------------	--	-------------------	-----------------------------

1.5 Албан шаардлага / төлбөрийн актын дугаарСЭА-2023/167-НА-СТА-ТШЗ	1.6 Огноо	2023.02.25	1.7 Мөнгөн дүн /төгрөгөөр/	1.963.0
--	------------------------------	-----------	------------	----------------------------	---------

1.8 Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох үндэслэл	Алдаа зөрчлийн товч утга	1. Төсвийг зохистой удирдаагүй, төлбөр тооцоог урьдчилан хянаагүйн улмаас "Мөнх ариун Сэлэнгэ" ХХК-д 225.0 мянган төгрөгийн өр төлбөр, ХХОАТ-ын 545.8 мянган төгрөг, НДШ-ийн 896.8 мянган төгрөг, цалингийн 295.4 мянган төгрөгийн зэрэг нийт 1,738.0 мянган төгрөгийн өр төлбөр шинээр үүсгэсэн , 2. 2022 оны жилийн эцсийн эд хөрөнгийн тооллого хийхдээ бичиг хэргийн материалыг тоолоогүй, бусад хангамжийн материалын тооллогын дүнг нэгтгэн дүгнээгүй байгаа 3. Шилэн дансны цахим хуудсанд мэдээлбэл зохих 9 мэдээллийг хугацаа хоцроосон байна.			
	Алдаа зөрчлийн ангилал	Хууль тогтоомжийн хэрэгжилт			
	Журмын заалт (4.2-оос аль тохирохыг оруулах)	4.2.1.11 "Хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн..."			
	Зөрчсөн эрх зүйн актын	Нэр	Төсвийн тухай хууль		
		Заалт	6.4.8		
		Нэр	Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль		
		Заалт	12.2.2, 20.2.5		
	Нэр	Шилэн дансны тухай хууль			
		Заалт	6 дугаар зүйл		
	Үндэслэл болгосон эрх зүйн актын	Нэр	Төрийн аудитын тухай хууль		
Заалт		21.1			
Нэр		Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаал			
Заалт		4.2.10, 4.2.11			

1.9 Төлбөр барагдуулах хэлбэр / төгрөгөөр/	Улсын төсвийн дансанд	1.10 Төлбөр, зөрчил барагдуулах огноо
	Орсон нутгийн төсвийн дансанд	
	Тухайн байгууллагын дансанд	

2. Үндэслэл болгосон гол нотлох баримтын талаарх мэдээлэл

№	Нотлох баримтын нэр төрөл	Дугаар	Огноо	Тайлбар
1	Төсвийн гүйцэтгэлийн тайлан, тооцоо нийлсэн акт, санхүүгийн тайлан	-	2022	Өр төлбөр үүсгэсэн
2	Хөрөнгийн тооллого	-	2022	Жилийн эцсийн эд хөрөнгийн тооллого бүрэн хийгдээгүй

3	Шилэн данс	-	2022	Шилэн дансны цахим бүртгэлд мэдээллийг бүрэн оруулаагүй
---	------------	---	------	---

3. Аудитын баг болон хариуцагчийн талаарх мэдээлэл

№	Аудитын багийн		Байгууллагын нэр	Хариуцагч		
	Овог нэр	Албан тушаал		Албан тушаал	Овог нэр	Холбоо барих хаяг, утас
1	Б.Наранчимэг	Аудитор	Сайхан сумын 1 дүгээр цэцэрлэг	Эрхлэгч	Т.Уранчимэг	99041559
				Нягтлан бодогч	Э. Батзаяа	91112572

4. Албан шаардлага, төлбөрийн акт бэлтгэх үеийн чанарын хяналт

4.1 Чанарын хяналт хийсэн тэмдэглэл

№	Албан тушаалтан	Огноо	Чанарын хяналтаар өгсөн санал зөвлөмж	Гарын үсэг
1	Аудитын менежер	<i>2/25</i>	-	<i>[Signature]</i>
2	Тэргүүлэх аудитор	<i>11/25</i>	-	<i>[Signature]</i>

4.2 Албан шаардлага, төлбөрийн актыг хэвлэмэл хуудсанд хэвлэх зөвшөөрөл

№	Албан тушаал	Овог нэр	Огноо	Гарын үсэг
1	Тэргүүлэх аудитор	Ч.Энхтуяа	<i>11/25</i>	<i>[Signature]</i>

5. Албан шаардлага, төлбөрийн актыг баталгаажуулж, хүргүүлэх үеийн баримтжуулалт

№	Үзүүлэлт	Мэдээлэл оруулах хэсэг		Гарын үсэг
1	Албан шаардлага, төлбөрийн актыг баталгаажуулсан тушаалын	Огноо		
		Дугаар		
2	Албан шаардлага, төлбөрийн актыг хүргүүлсэн албан бичгийн	Огноо		
		Дугаар		
3	Албан шаардлага, төлбөрийн актыг хүлээлгэн өгсөн	Огноо		
		Ажилтны	Овог нэр	Б.наранчимэг
			Албан тушаал	Аудитор
4	Албан шаардлага, төлбөрийн актыг хүлээн авсан	Байгууллагын нэр		Сайхан сумын 1 дүгээр цэцэрлэг
		Ажилтны	Овог нэр	Т.Уранчимэг
			Албан тушаал	Эрхлэгч
5	Албан шаардлага, төлбөрийн актын хэрэгжилтийг хариуцах	Газрын нэр		Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газар
		Ажилтны	Овог нэр	Б.Наранчимэг
			Албан тушаал	Аудитор
6	Тооцоолсон зөвшөөрүүлсэн үр өгөөж	Санхүүгийн	Тоо	
			Дүн	
		Санхүүгийн 6 ус үр өгөөжийн тоо		